



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/247

Хэрлэн сум

**“Биндэр-Ой” сум дундын  
ойн ангид дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад Ойн салбар үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Ойн газар”-аас Улаанбаатар хотод зохион байгуулж буй спортын 5 төрөлт тэмцээнд оролцох ойн салбарын баг тамирчидын замын зардалд зориулж “Биндэр-Ой” сум дундын ойн ангид 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ